



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 67

Чойр

Боловсролыг дэмжих дэд хөтөлбөр
батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “а”, “ж”, 25 дугаар зүйлийн 25.1, 25.4, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн, 15.2, 15.6, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Боловсролыг дэмжих дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт тусган санхүүжүүлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр тайлагнаж байхыг аймгийн Засаг дарга /Г.Батсуурь/-д даалгасугай.

3. Дээрх хөтөлбөр батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 63, 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 34 дүгээр тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Г. БАТЗАМ



БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Аймгийн Засаг даргын даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн Гуравдугаар бүлэг “Нийгмийн бодлого” зорилтын хүрээнд:

Зорилт: Цэцэрлэг, сургуулийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлж, боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах заалтын хүрээнд:

1. Боловсролыг дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлэх
2. Сургууль, цэцэрлэгийн барилгыг өргөтгөж, хүртээмжийг нэмэгдүүлэх
3. Сургууль цэцэрлэгийн орчинг тохижуулах
4. Сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах
5. Хувийн хэвшлийн цэцэрлэг шинээр байгуулахыг бодлогоор дэмжих гэж тодорхойлсон.

Энэхүү батлагдан хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгийн хүрээнд дэд хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөсөн.

Өнөөгийн байдал

Тус аймагт ерөнхий боловсролын 5 сургууль, төсвийн цэцэрлэг 5, хувийн цэцэрлэг 4, байгууллагын цэцэрлэг 1, нийт боловсролын 15 байгууллага, соёл урлагийн 5 байгууллага, Биеийн тамир, спортын газар үйл ажиллагаагаа явуулж байна.

2015-2016 оны хичээлийн жилд цэцэрлэгийн хамран сургалт 83,5 хувь, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 93,9 хувьд хүрч өмнөх оны түвшингээс хамран сургалт 1,2 хувиар өссөн, бага, суурь боловсролын хамран сургалт 100 хувийн үзүүлэлттэй байна.

2016-2017 оны хичээлийн жилд:

- Ерөнхий боловсролын 5 сургууль 122 бүлэгт 3.380 хүүхэд, 184 багш,
- Сургуулийн өмнөх боловсрол 43 бүлгийн 1.499 хүүхэд, 47 багш ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2016 онд шинээр 6 настан 369 хүүхэд элссэн.

Боловсролын салбарын хэмжээнд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд боловсролын шинэчлэлийн ажлыг дэмжиж, багш нарыг шинэ хөтөлбөр, стандартад сургах зардлыг санхүүжүүлсэн, хүүхдийн хөгжлийг дэмжиж, бүс, улсын уралдаан тэмцээнд оролцох зардлыг санхүүжүүлсэн, урамшуулсан, цэцэрлэг, сургуулиудын номын сан шинэ номоор баяжигдсан байна. Багшийн ажлыг үнэлж урамшуулснаар хүүхдийн сурлагын амжилт ахисан.

2016 онд манай аймаг Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр /468.6 хэмжээт онооны дундаж/ 21 аймгаас 9 дүгээр байранд орсон амжилтыг үзүүлсэн. Мөн цаашид элсэлтийн Ерөнхий шалгалтанд хангалтгүй дүн үзүүлж байгаа хичээлүүдийн дүнг улсын дундажд хүргэх, энэ хүрсэн байраа хадгалах улмаар улсад эхний 5 байранд орох эрмэлзэлтэй байна.

Боржигин өвийг өвлөн авч үлдэх талаар олон ажлыг хийсэн. Боржигин хошууны толь бичиг, боржигин овогтоны талаарх түүхийн ном гаргаж, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан. Ардын авьяастан болон мэргэжлийн уран бүтээлч нараар Боржигин уртын дуу, Боржигин морин хуурын сургалтыг 110 хүүхэд хийсэн байна.

Хүүхдийн сурлага, урлагийн авьяасыг дэмжиж, аймагтаа оюун ухааныг дэмжсэн олимпиад, мэтгэлцээн, уралдаан тэмцээнийг зохион байгуулах шаардлагатай байна.

Их, дээд сургуульд суралцах болон суралцаж байгаа хагас болон бүтэн өнчин, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн 146 хүүхдэд 200.000-700.000 төгрөгийн сургалтын тэтгэлэг олгож тухайн өрхийн амьжиргааг дэмжсэн.

Улсын болон аймгийн хөрөнгө оруулалтаар сургуулийн засвар, дотуур байрны засвар, сумдын Орон нутгийн хөгжлийн сангаар сурагч ширээ сандал, зөөлөн эдлэл, спорт заалны засвар хийх, хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Иймд хүүхдийг амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, төлөвшсөн, суралцах сургуулиа сонгох, мэргэжлээ сонгох, элсэн суралцах бэлтгэлийг хангах талаар хэрэгжүүлэх чиглэл, багш нарын гаргаж буй амжилтыг үнэлэх, боржигин өв, соёлоо дээдлэн хүндэлж, үр хойчдоо өвлүүлэн хадгалж үлдэх, бодлогын баримт бичигт тусгагдаагүй үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд энэхүү дэд хөтөлбөрийн ач холбогдол оршино.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим:

2.1. Говьсүмбэр аймгийн Хөгжлийн цогц бодлого, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 67 дугаар зорилтод үндэслэн төлөвлөж, зохион байгуулах.

2.2. Салбар хоорондын уялдаа холбоог хангаж, ил тод, боловсролын талаар тулгамдсан арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх

2.3. Төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоонд тулгуурлан, санал, санаачлагыг дэмжих замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.

Зорилго: Орон нутгийн онцлогт тохирсон боловсролын оновчтой бодлогыг хэрэгжүүлэн, багш, хүүхдийн хөгжил, авьяасыг дэмжиж, сургалтын чанар, үр дүнг дээшлүүлнэ.

Зорилт.1. Багшийн хөгжлийг дэмжих замаар сургалтын чанарыг ахиулна.

Зорилт.2. Боржигин ёс заншил, соёл, зан үйлийг хүүхэд багачуудад өвлүүлэх, хүүхдийн сурлага, урлагийн авьяасыг хөгжүүлнэ.

Зорилт.3. Нийгмийн эмзэг бүлэг болон орлого багатай айл өрхийн хүүхдийг дээд боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлнэ.

Хэрэгжүүлэх хугацаа: Хөтөлбөрийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан 2016-2020 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа

Зорилт.1. Багшийн хөгжлийг дэмжих замаар сургалтын чанарыг ахиулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Багш хүүхдийг хөгжүүлж буй шилдэг туршлага, арга зүйн талаар аймгийн зөвлөгөөн зохион байгуулах

2. Багш нарын шилдэг туршлагын талаарх гарын авлага боловсруулан хэвлэх, түгээх

3. Багшийн ёс зүй болон ажил мэргэжлийн сургалт зохион байгуулах

4. Хөдөөгийн багш нарын спортын тэмцээнийг аймагтаа зохион байгуулах

5. Улсын тэргүүний сургууль, цэцэрлэг болох бэлтгэл ажлыг хангах

6. Монголын болон Дэлхийн багш нарын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх

7. Монгол хэл, математик, англи хэлний аймгийн олимпиадуудыг зохион байгуулах

8. Математикийн улсын олимпиадыг аймагтаа хүлээн авах бэлтгэл ажлыг хангах, олимпиадыг зохион байгуулах

9. Элсэлтийн ерөнхий шалгалт, улсын олимпиад, уралдаан тэмцээнд амжилт гарган 1-3 дугаар байр эзэлсэн багш нарыг урамшуулах, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх

Зорилт.2. Боржигин ёс заншил, соёл, зан үйлийг хүүхэд багачуудад өвлүүлэх, хүүхдийн сурлага, урлагийн авьяасыг хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогт тохирсон "Боржигин ёс заншил, соёлын өв" сэдэвт хичээлийн гарын авлага боловсруулж, сургуулийн өмнөх нас, бага, дунд, ахлах ангид хичээл оруулах, хэрэгжүүлэх

2. Боловсролын чиглэлээр бүс, улсын чанартай уралдаан, тэмцээнд багш, сурагчдыг оролцуулах, хүүхдийн авьяас, хөгжлийг дэмжих

3. Боржигин өвийг тээгч, ардын авьяастан, мэргэжлийн уран бүтээлч нараар хүүхдүүдэд урлагийн дугуйлан, сургалт хичээллүүлэх, үр дүнг тооцох

4. Хүүхдийн оюун ухаан, авьяас билгийг хөгжүүлэх сургалтын төвүүдийг орон нутагт үйл ажиллагаагаа явуулах орчныг бүрдүүлэх, бодлогоор дэмжин ажиллах

Зорилт.3. Нийгмийн эмзэг бүлэг болон орлого багатай айл өрхийн хүүхдийг дээд боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагч ажил, мэргэжлээ сонгох, цаашид суралцах сургуулиа сонгох, элсэн суралцах, багш нарын мэргэжлийн хичээлд туслан зөвлөх багш ажиллуулах

2. Хагас болон бүтэн өнчин, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн оюутанд сургалтын тэтгэлэг олгох

Дөрөв. Үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт

Зорилт.1. Багшийн хөгжлийг дэмжих замаар сургалтын чанарыг ахиулна.

Үр нөлөө:

1. Багшийн сайн туршлага нийтийн хүртээл болж, сургалтын амжилт, чанар сайжирна.

2. Багш нарын ажлын амжилтыг урамшуулна.

3. Монгол хэл, математик, англи хэлний хичээлийн сургалтын чанар дээшилнэ.

4. Улсын тэргүүний сургууль, цэцэрлэгтэй болно.

5. Элсэлтийн ерөнхий шалгалт болон бусад улсын хэмжээнд зохиогддог олимпиад, уралдаан тэмцээнд оролцох багш, сурагчдын амжилт ахина.

6. Манай аймгийн боловсролын талаар барьж буй бодлогын талаарх сурталчилгаа, мэдээлэл хийгдэнэ.

Зорилт.2. Боржигин ёс заншил, соёл, зан үйлийг хүүхэд багачуудад өвлүүлэх, хүүхдийн сурлага, урлагийн авьяасыг хөгжүүлнэ.

Үр нөлөө:

1. “Боржигин өв, соёл, ёс заншил” сэдэвт орон нутгийн сургалтын хөтөлбөртэй болно.
2. “Боржигин өв, соёл, ёс заншил”-ыг хүүхэд багачуудад өвлүүлэн, үлдээх, хадгалах нөхцөл бүрдүүлнэ.
3. Аймаг, орон нутгаа төлөөлөн бүс, улсын чанартай уралдаан тэмцээнд оролцож буй хүүхдийн амжилтыг ахиулж, жилд медалийн тоо 10 хувиар нэмэгдэнэ.
4. Хэлний болон бусад чиглэлийн сургалтын төвүүд хичээллэж эхлэнэ.

Зорилт.3. Нийгмийн эмзэг бүлэг болон орлого багатай айл өрхийн хүүхдийг дээд боловсрол эзэмшихэд дэмжинэ;

Үр нөлөө:

1. Их дээд сургуульд орон нутгаас суралцагч 40 - 50 ядуу өрхийн гэр бүлийн суралцагчийг дэмжинэ.
2. Багш болон сурагчийн хичээл, сурлагын амжилт өмнөх оноос 0.1-2.0 хувь ахих

Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтүүд

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2016 он	Зорилтот түвшин			
				2017 он	2018 он	2019 он	2020 он
ХОЁР. НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД							
Боловсролын салбарын үзүүлэлт							
1	Улсын тэргүүний цэцэрлэг, сургуулийн болзол хангасан ЕБС,СӨБ-ын байгууллага	тоо	0	0	0	2	2
2	Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр улсад эзлэх байр	-	9	9	8	7	6
3	Ёс зүйн зөрчил гаргасан багш	тоо	0	0	0	0	0
4	Боржигин өв соёлыг өвлүүлэх сургалтанд хамрагдсан хүүхдийн тоо	тоо	110	150	200	250	300
5	Улсын олимпиадаас авсан медалийн тоо	тоо	1	1	2	2	3
6	Гадаад хэлний төв: - Үйл ажиллагаа явуулж байгаа гадаад хэлний төв	тоо	0	0	1	1	1
	- Сургалтанд хамрагдсан хүүхдийн тоо	тоо	0	0	10	20	30
7	ЕБС-ийн мэргэжлийн багшийн хангалт	хувь	98.8	99	100	100	100

8	Дугуйлан секц, клуб удирдсан багш, иргэдийн тоо	тоо	20	25	30	35	40
9	Тэтгэлэг:						
	- Дэмжлэг олгосон оюутан	тоо	58	25	25	25	25
	- Олгосон тэтгэмжийн хэмжээ	төгрөг	13.0	5.0	5.0	5.0	5.0

**Тав. Хөтөлбөрийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ,
санхүүжилтийн эх үүсвэр**

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр аймгийн Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг хангах бөгөөд шаардлагатай төсвийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд тусгана.

5.2. Хөтөлбөрийн арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалт, олон улсын төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхийг дэмжинэ.

5.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 4 жилийн хугацаанд нийт 184.0 сая төгрөг, жилд дунджаар 46.0 сая төгрөг шаардагдана. */Авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд шаардагдах төсвийг нарийвчлан тусгав./*

**Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ,
үнэлгээний төлөвлөгөө**

6.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд удирдлагаар хангах, дүн шинжилгээ хийх, Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь явцын хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Боловсрол, соёл, урлагийн газар, түүний харьяа боловсролын байгууллагууд, Боржигин чуулга, Номын сан, Музей хамтран хэрэгжүүлнэ.

6.3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь жил бүр хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийн, жилийн эцэст үр дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнана.



**Боловсролыг дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
/2016-2020 он/**

№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Санхүүжилт сая.төг	Хариуцах байгууллага
Зорилт.1. Багшийн хөгжлийг дэмжих замаар сургалтын чанарыг ахиулна.							
1	Боловсролын байгууллагыг чадварлаг, мэргэшсэн багшаар хангаж, багш нарын мэдлэгийг өндөр түвшинд хүргэх	Багш хүүхдийг хөгжүүлж буй шилдэг туршлага, арга зүйн талаар аймгийн зөвлөгөөн зохион байгуулах	2017,2019	Хамрагдсан багш нарын тоо Зохион байгуулсан зөвлөгөөний тоо	230 2	ОНХС 1.0	НБХ, БСУГ, ЕБС цэцэрлэгүүд
2		Багш нарын шилдэг туршлагын гарын авлага боловсруулан хэвлэх	2017,2020	шилдэг туршлагын гарын авлагын тоо	500 ширхэг	ОНХС 2.0	НБХ БСУГ
3		Багшийн ёс зүйн болон ажил, мэргэжлийн сургалт зохион байгуулах	2016-2020	Хамрагдсан багш нарын тоо Зохион байгуулсан сургалтын тоо	23 6	ОНХС 1,0	НБХ БСУГ
4		Хөдөөгийн багш нарын спортын тэмцээнийг аймагтаа зохион байгуулах	2017	Хамрагдсан багш нарын тоо Зохион байгуулсан тэмцээний тоо	Бүх багш нар 1-ээс доошгүй	ОНХС 5.0	НБХ БСУГ
5		Аймгийн тэргүүний сургууль, цэцэрлэг шалгаруулах журам гарган хэрэгжүүлэх	2016-2020	Тэргүүний сургууль, цэцэрлэгийн тоо	2-оос доошгүй	ОНХС 4.0	НБХ, БСУГ
6	Элсэлтийн Ерөнхий шалгалт, олимпиад, уралдаан	Монголын болон Дэлхийн багш нарын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх	2017-2020	Хамрагдсан багш нарын тоо Зохион байгуулсан арга хэмжээний тоо	230 3 удаа	ОНХС 4.0	НБХ, БСУГ
7	тэмцээний чанар, үр дүнг сайжруулах	Монгол хэл, математик, англи хэлний олимпиадуудыг зохион байгуулах	2017-2020	Зохиогдсон олимпиадын тоо Хамрагдсан	6-аас доошгүй 150-аас	ОНХС 8.0	НБХ, БСУГ, ЕБС

				хүүхдийн тоо	доошгүй		
8		Математикийн улсын олимпиадыг хүлээн авах бэлтгэл хангах, зохион байгуулах	2017-2018	Улсын олимпиад зохион байгуулах Хамрагдсан хүүхдийн тоо	1 150-аас доошгүй	ОНХС 40.0	НБХ, БСУГ
9		Элсэлтийн ерөнхий шалгалт, улсын олимпиад, уралдаан тэмцээнд амжилт гарган 1-3 дугаар байр эзэлсэн багш нарыг урамшуулах, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх	2016-2020	Амжилт гаргасан багшийн тоо Сурагчийн тоо.	10 багш 10 хүүхэд	ОНХС 10.0	НБХ, БСУГ
	ДҮН					75.0	

Зорилт.2. Боржигин ёс заншил, соёл, зан үйлийг хүүхэд багачуудад өвлүүлэх, хүүхдийн сурлага, урлагийн авьяасыг хөгжүүлнэ.

10	Боловсролын түвшин бүрт, боржигин соёл, зан үйлийг өвлүүлэх	Хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогт тохирсон "Боржигин ёс заншил, соёлын өв" сэдэвт хичээлийн гарын авлага боловсруулж, сургуулийн өмнөх нас, бага, дунд, ахлах ангид хичээл оруулах, хэрэгжүүлэх	2016-2020	Сургалтын хөтөлбөртэй болох	4 хөтөлбөр	ОНХС 4.0	БСУГ
11		Боловсролын чиглэлээр бүс, улсын чанартай уралдаан, тэмцээнд багш, сурагчдыг оролцуулах, хүүхдийн авьяас, хөгжлийг дэмжих	2016-2020	Уралдаан тэмцээний тоо Хамрагдсан хүүхэд	5-6 35-аас доошгүй	ОНХС 15.0	НБХ
12		Боржигин өвийг тээгч, ардын авьяастан, мэргэжлийн уран бүтээлч нараар хүүхдүүдэд урлагийн дугуйлан, сургалт хичээллүүлэх, үр дүнг тооцох	2016-2020	Сургалтанд хамрагдах хүүхдийн тоо	300-аас доошгүй	ОНХС 5.0	БСУГ
13		Хүүхдийн оюун ухаан, авьяас билгийг хөгжүүлэх сургалтын төвүүдийг хичээллэх орчныг бүрдүүлэх талаар дэмжин ажиллах	2017-2020	Сургалтанд хамрагдах хүүхдийн тоо	100-аас доошгүй	-	НБХ, БСУГ
	ДҮН					24.0	

Зорилт.3. Нийгмийн эмзэг бүлэг болон орлого багатай айл өрхийн хүүхдийг дээд боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлнэ.

14	Мэргэжлийн чиг баримжаа олгох, ахлах ангийн сонгон судлах цагийн үйл ажиллагааг дэмжих, багш нарын мэргэжлийн хичээлд зөвөлгөө өгөх	Зөвлөх багш ажиллуулах	2016-2020	Хамрагдсан багш	15 –аас доошгүй багш	ОНХС 25.0	НБХ, БСУГ, ЕБС
15	Оюутны сургалтын тэтгэлэг хэрэгжүүлэх.	Хагас болон бүтэн өнчин хүүхэд, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн оюутанд сургалтын тэтгэлэгийн дэмжлэг үзүүлэх	2016-2020	Орон нутгаас суралцах суралцагчийн тоо	50-аас доошгүй хүүхэд	ОНХС 60.0	НБХ
	ДҮН					85.0	
	НИЙТ					184.0	